

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Базар	Дугаар	L137
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Уулбаян
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Асрахуйгмандаандэлгэрүүлэгчхийд	Сүм хийдийн дугаар	СБУБ 033
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 2	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Мэргэн хутагтын хийд

Орлой мэргэн хутагтын хүрээ нь Орлойн баруун аймгийн Лагт хэмээх газар 1871 онд Асрахуйг мандаан дэлгэрүүлэгч хийд нэртэйгээр байгуулагджээ. Энэ хийд олноо Мэргэн хутагтын хүрээ гэж алдаршжээ. 20-аар зууны эхэн үед лам хуврагийн тоо 300 орчим байсан ба гол шүтээн нь Махгал байсан. Өдөр бүр Цогчэн хурахын зэрэгцээ Буддын шашны их, бага ухааныг судалдаг ухааны арван оронд мэргэшсэн эрдэм мэдлэгээрээ олон түмэнд гайхагдсан эрдэмтэн , мэргэд олноор төрөн гарч шашны гүн ухаан, зурхайн ухаан судалдаг зурхайч, оточ, авраач, гүрэмч нар сүсэгтэн олонд тусалдаг монголын томоохон хийдүүдийн нэг байжээ. 20-аар зууны эхэн үед мэргэн хутагтын хүрээг Богдын тамгатай долоон хутагтын нэг Ренчинбадам /сахилын алдар нь Лодойринчен/ удирдаж байжээ.